



JULY

ЖИЛИЙН ТАЙЛАН

2022

ШИНЭ ТЕХНОЛОГИ, ШИНЭ БОЛОМЖ, ШИНЭ
 СТРАТЕГИ ТУН УДАХГҮЙ

Нийгэмлэг нь 1994 онд байгуулагдаж, 1996 оноос Олон Улсын Гэр Бүл Төлөвлөлтийн Холбоо (ОУГБТХ)-ны гишүүн, 2005, 2010 онуудад Олон Улсад магадлан итгэмжлэгдсэн, 2015 оноос НҮБ-ын Нийгэм Эдийн Засгийн Зөвлөлтэй онцгой зөвлөлдөх статустай Монгол улс дахь анхны ТББ юм.

МГБССН нь одоогоор нийт 17 салбартай, Нөхөн үржихүй-эмэгтэйчүүдийн "Гэр бүл" эмнэлэг, Өсвөр үе залуучуудад эрүүл мэндийн мэдлэг олгох, зөвлөгөө өгөх 10 төвтэй, нийт 700-аад гишүүд, дэмжигчидтэйгээр үйл ажиллагаа явуулдаг.

Хүн амд бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрхийн талаарх боловсрол мэдлэг олгох, тусламж үйлчилгээ үзүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг сайн дурын, шашны бус, төрийн бус байгууллага юм.

2016-2022 ОНЫ СТРАТЕГИ АМЖИЛТТАЙ ХЭРЭГЖИЖ ДУУСЛАА

Нийгэмлэг өнгөрсөн 6 жилийн турш дараах стратегийн 4 үндсэн зорилго, 8 дэд зорилтыг хангаж ажилласан. Үүнд:

1. Бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд / БНҮЭМ/ ба эрхийн боловсрол олгох, тусламж үйлчилгээ үзүүлэх бодлого, эрх зүйн дэмжлэгт орчин бүрдсэн байна.
2. 1,3 сая хүнд, түүний дотор 15-34 насны өсвөр үе, залуучууд БНҮЭМ ба эрхийн мэдээлэл авч, мэдлэг, ур чадвар эзэмшсэн байна.

3. 1,6 сая хүн БНҮЭМ-ийн чанартай, цогц тусламж үйлчилгээ хүртсэн байна.

4. Сайн дурын идэвхитэн, гишүүд, дэмжигчиддээ тулгуурласан, чадварлаг хүний нөөцтэй, хариуцлагатай нэгдмэл байгууллага байна. Энэ хүрээнд хөндлөнгийн стратеги үнэлгээг зөвлөх доктор О.Тамир гүйцэтгэсэн бөгөөд стратегийн хэрэгжилтийг "сайн" гэж үнэллээ.





БНСУ-ын ХАЭМНХН-ийн Ерөнхийлөгч, доктор Чан Сун Ким, МГБССН-ийн Ерөнхийлөгч Б.Ганболд, гүйцэтгэх захирал Б.Мөнхцэцэг болон бусад зочид төлөөлөгчид оролцов. 2022.09.19, УБ хот

Монголын Гэр бүлийн сайн сайхны нийгэмлэг, БНСУ-ын Хүн амын эрүүл мэнд, нийгмийн хамгааллын нийгэмлэгийн хооронд 2022-2024 онд хамтран ажиллах харилцан ойлголцлын санамж бичгийг үзэглэсэн. Энэ хүрээнд Монгол улсын зорилтот бүлгийн хүн амд бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсрол олгох, алслагдсан орон нутгийн хүн амд эрүүл мэндийн чанартай тусламж үйлчилгээг үзүүлэхэд дэмжлэг үзүүлэх боломж бүрдсэн.

Тус нийгэмлэгийн хувьд 2007 оноос эхлэн Койка олон улсын байгууллагын санхүүжилтээр Төв, Өмнөговь, Архангай, Дорноговь аймгуудад Өсвөрийн дөрвөн төвийг байгуулж өгсөн юм.

Солонгосын Хүн амын эрүүл мэнд, нийгмийн халамжийн нийгэмлэгийн төлөөлөгчид Монголд айлчилж, нийгэмлэгийн үйл ажиллагаа, салбарын үйл ажиллагаатай танилцахын зэрэгцээ Эрүүл мэндийн яамны Бодлого төлөвлөлтийн газартай уулзалт хийж, цаашид манай нийгэмлэгтэй хамтын ажиллагааг өргөжүүлэх, хамтран төсөл хөтөлбөр хэрэгжүүлэхээр тохиролцсон юм.

Ерөнхийлөгч, доктор Чан Сун Ким болон бусад төлөөлөгчид манай Төв аймгийн салбарын үйл ажиллагаатай танилцаж, Өсвөрийн эмч клубын хүүхдүүдийн танилцуулга, урлагын тоглолтыг үзэж сонирхон, Бяцхан эмч клубын хичээл, Өсвөрийн эмч клубын өртөөчилсөн сургалт өдөрлөгийн үйл ажиллагаанд оролцлоо.

СОЛОНГОСЫН НИЙГЭМЛЭГТЭЙ ХАМТЫН АЖИЛЛАГАА ТЭЛЭВ



Солонгосын төлөөлөгчид Гэр бүл эмэгтэйчүүдийн эмнэлгийн үйл ажиллагаатай танилцав.



ЭМЯ-ны холбогдох удирдлагуудтай уулзалт хийж, хамтран ажиллахаар тохиролцов.



Төв аймгийн Нэгдсэн эмнэлэгт Эх нярайн өрөөнд зориулан зарим шаардлагатай тоног төхөөрөмж, аппарат хэрэгслийг гардууллаа

Монголын Гэр бүлийн сайн сайхны нийгэмлэг, БНСУ-ын Хүн амын эрүүл мэнд, нийгмийн хамгааллын нийгэмлэг хоорондын хамтын ажиллагааны хүрээнд Төв аймгийн Нэгдсэн эмнэлэгт Эх нярайн өрөөнд зориулан зарим шаардлагатай тоног төхөөрөмж, аппарат хэрэгслийг гардууллаа.

Энэ үеэр МГБССН-ийн Ерөнхийлөгч Б.Ганболд: "Хоёр нийгэмлэгийн хамтын ажиллагааны хүрээнд харилцан эмч мэргэжилтнүүдийг сургах, туршлага солилцох олон боломж нээгдэнэ" гэдгийг онцолсон юм.

ТУРШЛАГА СУДЛАХ ГРУПП СОЛОНГОСТ АЙЛЧЛАВ



Солонгосын нийгэмлэг нь эх хүүхдийн эрүүл мэндийн хөтөлбөрийн хүрээнд: Жирэмсэн эмэгтэйчүүдийн сургалт, Хосуудын сургалт, Эцэг эхийн сургалт, Аавуудын сургалт, Ганц бие эхчүүдийн хөтөлбөр, Хүнд өвчтэй хүүхдүүдийн эмчилгээнд хандив цуглуулах зэрэг ажлуудыг зохион байгуулдаг.

Гэр бүлийн эрүүл мэндийг дэмжих хүрээнд:

13 салбар эмнэлгээр дамжуулан эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлдэг.

- Төрсний дараах үзлэг, үйлчилгээ
- Чихрийн шижин өвчний хяналт
- 12-65 нас хүртэлх хүмүүсийн 11 төрлийн ханиадны оношилгоо
- Сүрьеэ, гепатит А, В вирус, хомхой, менингокк
- Үтрээ, хөх, ходоод, элэг, умайн хүзүүний хорт хавдрын илрүүлэг
- 6 наснаас доош хүүхдийн үзлэг эмчилгээ хийдэг байна.

МГБССН, БНСУ-ын Хүн амын эрүүл мэнд, нийгмийн халамжийн нийгэмлэгтэй хамтран ажиллах санамж бичгийн дагуу Туршлага солилцох групп Солонгос улсад 11-р сард айлчиллаа.

Тус нийгэмлэг нь хүн амын эрүүл мэнд тэр дундаа, нөхөн үржихүйн эрүүл мэнд, боловсрол олгох, тусламж үйлчилгээ үзүүлэх чиглэлээр ажилладаг томоохон байгууллага юм. Нийт 13 салбар эмнэлэгтэй.



Даежеон дахь Залуусын бэлгийн боловсролын төвд зочилж, залуучуудад гэр бүл төлөвлөлт, бэлгийн боловсролыг хэрхэн олгодог талаарх танилцуулга хичээл, сургалтын хэрэглэгдэхүүн, өрөө тасалгаатай танилцаж, туршлага судлав.



Айчлалын баг Монгол, БНСУ, Вьетнам зэрэг 3 улсын залуусын "Нөхөн үржихүйн эрүүл мэндийн нөхцөл байдал"-ын судалгааны үр дүнг Солонгосын Хөх ордонд танилцуулав. Энэ үеэр парламентын гишүүд оролцсон байна.





Төв аймаг: Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийн хүрээнд Төв аймаг дахь салбарын дэргэдэх Өсвөрийн эмч клуб хамтран дурсамж бүтээе гар зураг, оригами цаасан урлал, ask a simple question in english контент, Бяцхан эмч нарын зөвлөмж хүргэж ажиллалаа. Давхардсан тоогоор 500 гаруй хүүхдэд хүрч үйлчилсэн байна.

ӨСВӨРИЙН ЭМЧ КЛУБ



Дорнод: Өсвөрийн гишүүн хүүхдүүд өөрсдийн гараар гоёл, чимэглэлийн зүйл урлаж, сайн дурын ажилд хөрөнгө бүрдүүлэх санаачлага гаргалаа.



Архангайн Хашаат сум: ХДХВ/ДОХ-ын өдрийн хүрээнд ЕБС сурагчдын дунд мэдлэг шалгах тэмцээн, жүжигчилсэн тоглолтыг зохион байгууллаа.

Өсвөрийн эмч клуб Дорнод, Өвөрхангай, Өмнөговь, Булганы Сайхан, Баянхонгор, Төв, Орхон, Дорноговь, Дархан салбарын гишүүд идэвхтэй үйл ажиллагаа явууллаа.

- Үе тэнгийн сургагч бэлтгэх сургалт
- Ганцаарчилсан дэмжлэг үзүүлэх
- Эцэг эхчүүдэд зориулсан уулзалт, сургалт
- Олон нийтэд зориулсан мэдээлэл сургалт сурталчилгааны үйл ажиллагаа, спорт өдөрлөг, мэдлэгийн тэмцээн
- Охидын өдөр
- Оюутны эрүүл мэндийг дэмжих сар зэрэг олон ажлуудыг зохион байгуулж ажилласан.



Орхон аймгийн 15 ЕБС-ын сурагчдад нөхөн үржихүйн эрүүл мэндийн талаар сургалт хийлээ.



Сүхбаатар: Сургалтанд 11, 12 дугаар ангийн 60 гаруй сурагчид хамрагдсан ба мэдлэг баталгаажуулах асуулт хариултаар маш амжилттай зохион байгуулагдлаа.



"Бяцхан эмч" клубыг Өвөрхангай, Архангайн Хашаат, Орхон аймгийн салбарууд шинээр байгуулж, "Гарын ариун цэвэр", "Амны хөндийн эрүүл мэнд" хичээл, хувийн орон зай буюу "Харилцааны цагираг" хичээл, "Хувийн ариун цэвэр" зэрэг хичээлийг зааж үйл ажиллагааг хэрэгжүүлж эхэлсэн.




Өмнөговь Цогт-Овоо сумын иргэд

Явуулын үзлэг: Орон нутгийн Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлэг болон өрх, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудтай хамтран найман салбар явуулын тусламж үйлчилгээг хэрэгжүүллээ. Нийт найман аймгийн 20 389 хүнд 30 нэр төрлийн тусламж үйлчилгээг үзүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллаа.

- Булганы Сайхан
- Увс
- Төв
- Өвөрхангай
- Өмнөговь
- Орхон
- Улаанбаатар
- Дархан-Уул

АЛСЛАГДСАН ХҮН АМД ЯВУУЛЫН ҮЗЛЭГ ХИЙЛЭЭ





ГЭРЭЭТ ЭМНЭЛГҮҮДЭЭР ДАМЖУУЛАН ЗОРИЛТОТ БҮЛГИЙН ХҮН АМД ЖИРЭМСЛЭХЭЭС СЭРГИЙЛЭХ АРГА ХЭРЭГСЛИЙГ ТҮГЭЭВ

- Дархан аймаг- Аминхолбоо ӨЭМТ
- Дорнод аймаг-Асралт үйлс ӨЭМТ
- Орхон аймаг-Нийцэл ӨЭМТ
- Өмнөговь аймаг-Энхийн хүслэн
- Өвөрхангай аймаг-Нарны дөш ӨЭМТ

- Нийслэлийн Өргөө амаржих газар
- Баянгол дүүрэг-Бичилманал ӨЭМТ
- Баянгол дүүрэг-Ашид амгалан ӨЭМТ
- Баянзүрх дүүрэг-Ачлахуй ӨЭМТ
- Баянзүрх дүүрэг-Эрүүл оршихуй ӨЭМТ
- Баянзүрх дүүрэг-Эрүүл мэндийн төв
- Сонгинохайрхан дүүрэг-Гурвансанчир ӨЭМТ
- Сүхбаатар дүүрэг-Эрүүл мэндийн төв



МОНГОЛД АНХ УДАА ИСПАНИ ЕРӨНДГИЙГ ГЭР БҮЛ ЭМНЭЛЭГТ ТАВЬЖ ЭХЛЭВ

2022 оны хувьд Гэр бүл эмэгтэйчүүдийн эмнэлэг эмэгтэйчүүдийн үзлэг зөвлөгөө, Хэт авиан оношлогоо, гэр бүл төлөвлөлтийн үйлчилгээ, шинжилгээ, эмчилгээ гэсэн 5 үндсэн төрлийн 30 гаруй үйлчилгээгээр жилдээ 6000 гаруй эмэгтэйчүүд, гэр бүлд зөвлөгөө үйлчилгээ үзүүлсэн байна.

Бид энэ жил Монголд анх удаа Испани улсын алтжуулсан, мөнгөжүүлсэн, охидын ерөндгийг тавьж эхэлсэн бөгөөд нөхөн үржихүйн насны хүн амд жирэмслэхээс сэргийлэх арга хэрэгслийн сонголтыг өргөн болгох нэг алхам хийгдлээ гэж үзэж байна.

Мөн үргүйдлийн зөвлөгөө, хөхний үзлэг зөвлөгөөг хийж эхэлсэн бөгөөд PCR шинжилгээг авч байгаа нь үйлчлүүлэгчдийн талархлыг хүлээгээд байна.

- Үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн судалгаагаар нийт сэтгэл ханамжийн түвшин 96,5 хувь буюу "сэтгэл хангалуун" гэсэн дүгнэлт гарсан.
- Эмч ажилчдаа Камбож, Солонгос улсад туршлага солилцуулж, мэдлэг ур чадварыг нь дээшлүүлээ.

The advertisement features a white background with a red ribbon in the top left corner. A light blue IUD device is shown diagonally across the center. The text is in both English and Mongolian. The English text includes 'eurogine 30 YEARS', 'Gold T® IUD (Cu375+Au)', and 'NEW ARRIVAL'. The Mongolian text reads 'ИСПАНИ АЛТЖУУЛСАН ЕРӨНДӨГ МОНГОЛД АНХ УДАА' and 'Европ стандартын шаардлага хангасан Испанийн АЛТЖУУЛСАН, МӨНГӨЖҮҮЛСЭН, ОХИДЫН ЕРӨНДГИЙГ ГЭР БҮЛ ЭМНЭЛЭГТ ТАВЬЖ ЭХЭЛЛЭЭ.' At the bottom, there are social media icons for Facebook and WhatsApp, along with the phone number 7018 6180.

eurogine 30 YEARS

ИСПАНИ АЛТЖУУЛСАН
ЕРӨНДӨГ
МОНГОЛД АНХ УДАА

Gold T® IUD (Cu375+Au)

Европ стандартын шаардлага хангасан
Испанийн АЛТЖУУЛСАН, МӨНГӨЖҮҮЛСЭН, ОХИДЫН ЕРӨНДГИЙГ
ГЭР БҮЛ ЭМНЭЛЭГТ ТАВЬЖ ЭХЭЛЛЭЭ.

NEW ARRIVAL

f Гэр бүл эмэгтэйчүүдийн эмнэлэг

7018 6180



Камбож улсад болсон "Үйлчлүүлэгч төвтэй чанартай тусламж үйлчилгээний үнэлгээний семинарын үеэр, 2022.10-р сар



IPPF СТАНДАРТЫН ДАГУУ ӨӨРИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙЛЭЭ

IPPF ESEAOR /Олон улсын гэр бүл төлөвлөлтийн холбооны Зүүн ба зүүн өмнөд Ази, Номхон Далайн бүс/-ээс зохион байгуулсан "Үйлчлүүлэгч төвтэй үйлчилгээ, чанартай тусламж үйлчилгээний үнэлгээ"-г хэрхэн хийх, аргачлалыг нэвтрүүлэх сургалтанд амжилттай хамрагдлаа. Сургалтанд Индонез, Малайз, Монгол, Филиппин, Тайланд, Камбож, Лаос, Вьетнам, Мьянмар, Тайланд зэрэг 11 орны нийгэмлэгийн эмнэлгийн менежер, эмч нар оролцов. Тус сургалтанд нийгэмлэгийн менежер Х.Өнөрсайхан оролцов.

Камбожийн сургалтаар олж мэдсэн "Үйлчлүүлэгч төвтэй чанартай тусламж үйлчилгээ"-г өргөжүүлэх бодлогын хүрээнд IPPF ESEAOR Virtual quality assessment tools-ийг ашиглан Гэр бүл эмэгтэйчүүдийн эмнэлэг эмнэлгийн үйл ажиллагаанд өөрийн үнэлгээг амжилттай хийж, холбогдох төлөвлөгөөг гарган ажиллаа. Үйлчлүүлэгчээр жолоодуулсан, тэдний өвөрмөц хэрэгцээ шаардлагыг мэдэрсэн, тэдний санал гомдлыг тусгадаг тасралтгүй цогц тусламж үйлчилгээг бүрдүүлэх нь Чанартай тусламж үйлчилгээний ГОЛ ЦӨМ юм.

НАМАЙГ УНШУУЛААРАЙ



МАНАЙ ҮЙЛЧИЛГЭЭ ТАНД ТААЛАГДСАН УУ?

Гэр бүл эмнэлгийн үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн судалгааг QR /онлайн/ авдаг болов.



Төлбөрийн уян хатан нөхцлийг санал болгож Storepay үйлчилгээнд нэгдлээ.



БНХАУ-ын Гэр бүл төлөвлөлтийн нийгэмлэгт зочилж, эмнэлгийн үйл ажиллагаатай танилцаж, харилцан туршлага солилцов.



БНСУ-ын Хүн амын эрүүл мэнд, нийгмийн халамжийн нийгэмлэг, эмнэлгийн үйл ажиллагаатай танилцав.



ГЭРЭЭТ ЭМНЭЛГҮҮДЭЭР ДАМЖУУЛАН ЗОРИЛТОТ БҮЛГИЙН ХҮН АМД ЖИРЭМСЛЭХЭЭС СЭРГИЙЛЭХ АРГА ХЭРЭГСЛИЙГ ТҮГЭЭВ



- Дархан аймаг- Аминхолбоо ӨЭМТ
- Дорнод аймаг-Асралт үйлс ӨЭМТ
- Орхон аймаг-Нийцэл ӨЭМТ
- Өмнөговь аймаг-Энхийн хүслэн
- Өвөрхангай аймаг-Нарны дөш ӨЭМТ

- Нийслэлийн Өргөө амаржих газар
- Баянгол дүүрэг-Бичилманал ӨЭМТ
- Баянгол дүүрэг-Ашид амгалан ӨЭМТ
- Баянзүрх дүүрэг-Ачлахуй ӨЭМТ
- Баянзүрх дүүрэг-Эрүүл оршихуй ӨЭМТ
- Баянзүрх дүүрэг-Эрүүл мэндийн төв
- Сонгинохайрхан дүүрэг-Гурвансанчир ӨЭМТ
- Сүхбаатар дүүрэг-Эрүүл мэндийн төв



ХАЙРЫН ЗАХИА, ШОКОЛАДНЫ ХАМТ ХҮРГЭВ 34 шоколад, мэндчилгээ 30 онлайн мэндчилгээ ирлээ!



Дархан: Охид бие биенийхээ эрхийг зөрчихгүй байхыг уриалав

Аймгийн Уул Уурхай Эрчим Хүчний политехник коллежийн оюутнуудад "Хүчирхэг охид" сургалтыг зохион байгуулж, охидын эрхийн талаар мэдлэг олгож охид бие биенийхээ эрхийг зөрчихгүйгээр хамтдаа хэрхэн хөгжих талаар ярилцлаа.

Зайлшгүй мэдэх нь зөв зөвлөгөө болдог

Дорноговь: Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсрол олгох, мэдлэг мэдээлэл өгөх зорилгоор эцэг эх, асран хамгаалагч болон хүүхдүүдийг хамруулан сургалт, хэлэлцүүлгийн арга хэмжээг зохион байгууллаа. Аймгийн хэмжээнд нийт 247 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд байгаагаас 149 хүүхэд боловсролын үйлчилгээнд хамрагдсан.

Өмнөговь: Үе тэнгийн зөвлөгч хүүхдүүддээ талархаад баршгүй

Өсвөр үеийн төвийн идэвхитэй ажиллаж буй манлайлагч Үе тэнгийн зөвлөгч, сургагч багш нарыг олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөрт Талархал гардуулан хүүхдийн бэлгээр шагнаж урамшууллаа.



Мини театр Баадийгийн адал явдлыг тоглов

Төв: Аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газартай хамтран Мөнх-Алдарын талбайд зуны зугаатай өдрүүд арга хэмжээг зохион байгууллаа. Өсвөрийн эмч клубын хүүхдүүд маань Баадийгийн адал явдал үлгэрийн мини театраар сургамжит жүжиг тоглож үзүүллээ. Wish wings бүжгийн хамтлаг та нартаа flash mob заалаа.

Өмнөговь: Үе тэнгийн зөвлөгч хүүхдүүддээ талархаад баршгүй

Өсвөр үеийн төвийн идэвхитэй ажиллаж буй манлайлагч Үе тэнгийн зөвлөгч, сургагч багш нарыг олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөрт Талархал гардуулан хүүхдийн бэлгээр шагнаж урамшууллаа.



Говь-Алтай: Нийгэмлэг 16 дахь салбараа Говь-Алтай аймагт нээлээ. Салбарын тэргүүнээр хүний их эмч Г.Дулмаа томилогдож, Говь-Алтай аймгийн Анагаах ухааны их сургууль, цэцэрлэг, ЕБС-ийн эрхлэгч, эмч, ӨЭМТ-ийн эмч ажилтнууд болон аймгийн төрийн захиргааны байгууллагын ажилтнууд зэрэг төрөл бүрийн гишүүдээр эгнээгээ өргөжүүлж салбарын хурлаа хийлээ.

ГОВЬ-АЛТАЙ, ХОВД АЙМАГТ ШИНЭ САЛБАРАА НЭЭЛЭЭ

ховд: Монголын Гэр бүлийн сайн сайхны нийгэмлэг дахин бүл нэмж 17 дахь салбараа Ховд аймагт байгуулж, салбарын тэргүүнээр Б.Одонпүрэвийг томиллоо.



Мини театр Баадийгийн адал явдлыг тоглов

Төв: Аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газартай хамтран Мөнх-Алдарын талбайд зуны зугаатай өдрүүд арга хэмжээг зохион байгууллаа. Өсвөрийн эмч клубын хүүхдүүд маань Баадийгийн адал явдал үлгэрийн мини театраар сургамжит жүжиг тоглож үзүүллээ. Wish wings бүжгийн хамтлаг та нартаа flash mob заалаа.

2022 оны шилдгүүддээ шагналыг гардууллаа



Дархан салбарын тэргүүн
Д.Должналжирмаа

2022 оны салбаруудын үйл ажиллагааны тайлан, үнэлгээгээр 15 салбараас шилдгүүд тодорлоо.

Тэргүүн байрт: Дархан салбар

Дэд байрт: Төв аймгийн салбар

Гутгаар байрт: Өвөрхангай аймгийн салбар, Өмнөговь аймгийн салбар тус тус шалгарсан юм.

Та нар минь бусдын төлөө, нийгмийн сайн сайхны төлөө өөрсдийнхөө их ажлын хажуугаар, цаг заваа гарган оюун сэтгэлээ зориулдаг үнэхээр их буянтан, ачтангууд юм шүү.

ОЛОН УЛСЫН ГЭР БҮЛ ТӨЛӨВЛӨЛТИЙН ХОЛБОО 70 НАС ХҮРЛЭЭ



Колумб улсын нийслэл Богота хотод Олон Улсын Гэр Бүл Төлөвлөлтийн Холбооны Ерөнхий Ассембли 2022 оны 11 дүгээр сарын 21-25-ны өдрүүдэд зохион байгуулагдав. Тус хуралд МГБССН-ийн Ерөнхийлөгч Б.Ганболд, гүйцэтгэх захирал Б.Мөнхцэцэг, Удирдах зөвлөлийн гишүүн, Төв аймгийн Хүмүүн ахлах сургуулийн 11-р ангийн сурагч Х.Ренчинсоном нар оролцсон. Ерөнхий Ассемблейгаар өнгөрсөн 3 жилийн ололт, амжилт, бэрхшээлийн талаар ярилцаж, ирэх 5 жилийн стратеги төлөвлөгөөг хэлэлцэж батлав. ОУГБТХ нь дэлхийн 150 гаруй улсад гишүүн нийгэмлэгтэй бөгөөд бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрхийн чиглэлээр боловсрол, тусламж үйлчилгээг үзүүлэхэд дэмжлэг үзүүлдэг томоохон иргэний нийгмийн хөдөлгөөн юм.

